

«АЗ СОРЬСОН ҮЙЛДЭЛ» : АЮУЛ УУ? ХӨГЖИЛ ҮҮ?

А.АМАРСАНАА

МУИС, ШУС, Антропологи, археологийн тэнхим, e-mail: am_sanaa@num.edu.mn

ТҮЛХҮҮР ҮГС: амь дүйсэн үйлдэл, азаа турших, санаатайгаар эрсдэлтэй учрах, хүрээлэн буй орчны нөлөө, залуучууд

ХУРААНГУЙ. *Аз сорьсон үйлдэл нь гарах үр дүнгээсээ хамаарч нэг талаас хөгжлийн түлхүүр болдог бол нөгөө талаас аюул осолд өртөх сөрөг талтай. Хүн төрөлхтөн хэдийнээс өөрсдийгөө эрсдэлээс хамгаалж ирсэн бол орчин үед санаатайгаар аюултай учрах эрсдэлтэй үйлдлүүд ихэд үйлдэх болжээ. Энэ нь өөрсдийнхөө чадварыг таних, хүлэгдмэл байдлаас гарах боломжийг олгодогтой холбоотой байдаг. Энэхүү өгүүлэлдээ бид монголын өсвөр насныхан аз сорьсон үйлдлүүдээрээ юуг эрэлхийлж байгааг дүгнэн шинжилнэ.*

Европт аз сорьсон үйлдэл ихэд яригдах болсон нь эрсдэл дагуулсан спорт түлхүү хөгжих болсонтой холбоотой. Тиймээс ч энэ нь орчин үеийн антропологийн судалгааны шинэ сэдвийн нэг болж чадсан байна. Бид тус өгүүллээр зарим нэг антропологчдын энэхүү сэдвээр хийсэн судалгаа, тэдний дэвшүүлсэн санаануудтай танилцах болно. Мөн манай залуучуудын дунд хэрхэн аз сорьсон үйлдэлтэй харьцаж байгааг бид нягтална.

Аз сорьсон үйлдэл, түүний ойлголтууд

Азаа сорих гэдэг нь “risk”(англиар), “risque” (францаар), “риск” (оросоор) эрсдэл дагуулах сөрөг үйлдэл юм. Тухайлбал “risque” гэсэн үгийг Франц хэлний тайлбар толиноос харвал хоёр санааг агуулах бөгөөд эхнийх нь “*их бага хэмжээгээр мэдрэгдэж байгаа учирч болох аюул*”, дараагийнх нь “*санаатайгаар аюултай учрах*” гэсэн байна. Юуны өмнө азаа сорьсон үйлдэл нь аюул осол гэдэгтэй холбогдож байна. Зохиогч Дорждэрэмийн “Франц монгол толь бичиг”-ээс “risque” үгийн

орчуулгыг харахад: 1. *аюул, осол* 2. *азаа турших, азаа үзэх* гэсэн хоёр үндсэн утгаас гадна эдгээр үгүүдтэй холбоотой: *аюултай, аюул тохиолдмоор, аюулд орох, эрсдэх* гэх мэт үгүүд бичигдсэн байна. Мөн уг үг нь *зүрхлэх, зориглох, бас үзээд алдах* гэсэн үгүүдээр давхар орчуулагдсан байна. Дээрхийг эмхэтгэхэд нэг талаас аюул осол гэсэн сөрөг утга агуулж байхад нөгөө талаас үзээд алдах, азаа турших гэсэн хөгжлийг илэрхийлсэн эерэг утгууд зэрэгцэн оршиж байна.

Аз сорьсон үйлдлийн үр дүнгээс шалтгаалан эсрэг тэсрэг хоёр агуулга бүхий аюул тохиох эсвэл аз тохиох гэсэн утга бий болно. Тэгвэл аз сорьсон үйлдэл нь нэг бол азтай учрах эсвэл эрсдэлд өртөх гэж хуваагдах боломжтой. Хийсэн үйлдэл маань ямар үр дүн авчрахаас шалтгаалж нэг бол эрсдэлд өртөх эсвэл аз дайрах гэсэн эсрэг тэсрэг хоёр утгыг илтгэж байна. Бид уг өгүүлэлдээ энэхүү хоёрдмол санааг нягтлах болно.

Аюул осол бидний амьдралд өдөр тутам тохиолддог. Хоолоо хийж байгаад гараа зүсэх, цахилгаан хэрэгслээр оролдож байгаад гүйдэлд цохиулах, мод хагалж байгаад гэмтэх, гадаа гудамжинд бүдэрч унах гэх мэт осол эндэгдэлд бид хэзээ ч өртөх боломжтой. Нэг үгээр эдгээр осол эндэгдэл гэр орон, ажлын байр, гадаа гудамжинд, ер нь хаа сайгүй тохиолдож болох юм.

Эрсдэл нь бие махбодид хор хөнөөлтэй байхаас гадна бас сэтгэл санаатай холбоотой байж болно. Жишээлбэл, хэн нэгэн зохиолч уран бүтээлээ туурвихдаа өөрийн гэсэн өвөрмөц бичгийн хэв маягийг ашигладаг байснаа түүнийгээ өөрчлөх үед бэрхшээлүүдийг авч үзье. Хэдийгээр үүнийг аюул, эрсдэл гэж хэлж болохгүй ч гэсэн түүний бичлэгийн арга барилаа өөрчилсөн байдал нь уншигчдаа алдах, шүүмжлэлд өртөх гэх мэт эрсдэл дагуулна. Тиймээс аз сорьсон үйлдэл нь зөвхөн бие махбодоор бус мөн хувь хүний сэтгэл санааг доройтуулж болох муу нөлөөтэй байна. Үүнээс дүгнэхэд эрсдэл нь бие махбодын болоод оюун санааны гэсэн хэлбэрүүдтэй байдаг байна.

Эрсдэл нь бидний өдөр тутмын амьдралд олонтоо тохиолддог гэж хэлэхэд хилсдэхгүй. Хэдий тийм ч бид тохиолдож болох эрсдлээс өөрсдийгөө байнга хамгаалж чаддагт гол учир оршино. Ямар нэгэн үйлдэл хийхдээ анхаарлаа төвлөрүүлэх эсвэл аюулгүй байдлыг хангах багаж зэвсэг, хамгаалалтын хувцас зэрэг хэрэгслүүдийг ашигладаг. Тиймээс бид аз сорих үйлдэл хийхдээ ирж болох эрсдлийг урьдаас тооцоолдог. Энэ нь дадал туршлагатай холбоотой. Тиймээс бид бага наснаасаа аюул ослоос биеэ хамгаалах талаар заалгаж ирсэн. Бид зарим үйлдлийг бага наснаасаа бүрэн эзэмшиж чадсан байдаг учраас итгэлтэйгээр үйлдлээ хийдэг нь эрсдлээс

өөрсдийгөө хамгаалах боломж өгдөг. Энэ тохиолдолд өөртөө итгэх итгэл нь гарч болох эрсдэлээс илүү өндөр хувьтай байна. Ажил хөдөлмөрийн явцад тохиолдож болох гамшгаас мөн л биеэ хамгаалж сурдаг. Тэгэхээр өөрийнхөө үйлдэлд эзэн болоход зарцуулсан цаг хугацаа, үе үеийхэндээ өвлүүлэн үлдээсэн мэдлэг туршлага нь биднийг аюулаас сэргийлж өгдөг байна. Тиймээс ахмад хүмүүс хойч үеийнхэндээ хуримтлуулсан туршлагаа эзэмшүүлэхийг оролддог. Энэ нь тохиолдож болох аюулыг аль болохоор багасгах буюу түүнээс урьдчилан сэргийлэх чадварыг эзэмшүүлнэ гэсэн үг юм.

Эрсдэлээс урьдчилан сэргийлэх олон арга байдаг боловч түүнээс болгоомжлох байдлыг мартдаг шалтгаанууд бас цөөнгүй байна. Жишээлбэл ядрах, тоомсоргүй байх, анхааралгүй байх, аюулыг ухамсарлаж ойлгоогүй, аюултай гэж мэдээгүй байх гэх мэт үеүдийг дурдаж болно. Хүний амь нас нь энгийн нэгэн үйлдэл болох гудамж хөндлөн гарахаас эхлээд мэргэжлийн гэгдэх ажлуудад, мөн спортын болон чөлөөт цагаа өнгөрүүлэх үед ч хохирч болох аюултай байна. Хүний амь нас байнга аюул эрсдэлтэй орчинд байдаг учраас бид эрсдэлээс хамгаалах арга барилд байнга суралцаж байдаг.

Эрсдэл тохиох явцыг нягтлан үзвэл нэг талаас бид эрсдэлд гадны хүчин зүйлээс шалтгаалж санамсаргүйгээр өртдөг бол, нөгөө талаас азаа турших буюу үйлдэгч этгээд өөрөө эрсдэлтэй учрахыг хүссэн тохиолдлууд бас байдаг. Хэрвээ бид ирж болох аюулаас өөрсдийгөө урьдчилан сэргийлдэг юм бол ямар учраас тэр аюул гэдэгт санаатайгаар өртөхийг хүсдэг юм бэ? гэсэн асуулт өөрийн эрхгүй гарч ирж байна.

Юуны өмнө бид эрсдэлтэй учрахыг *тохиолдлын чанартай эрсдэлд өртөх* эсвэл *эрсдэлийг санаатайгаар бий болгох*

гэж хуваая. Дээрх хэсэгт бид эрсдэлд тохиолдлын чанартай өртөх гэдэг утга дээр ярилцаж түүнээс урьдчилан сэргийлэх талаар авч үзсэн. Эрсдэлийг санаатайгаар бий болгох гэсэн санаа нь аюул гэдэг зүйлтэй санаатайгаар азаа турших явдлыг хэлж байна. Зарим тохиолдолд үйлдэгч этгээд учрах аюулыг ухамсарлан ойлгоогүйгээр эрсдэлд өртдөг. Ямар нэгэн гадны нөлөөнөөс болж санамсаргүйгээр эрсдэлд өртөх болон өөрөө санаатайгаар эрсдэлд өртөх хоёрыг адилхан тайлбарлаж болохгүй байх. Аюул гэдэг зүйлтэй азаа сорьсон үйлдлүүд болон ажлаа хийж байгаад эрсдэлд өртөх хоёр хоорондоо маш ялгаатай. Өөрөөр хэлбэл эрсдэлийг ухамсарлан үйлдсэн эсвэл түүнд өртсөн гэсэн ялгаа байна. Тиймээс бид амь дүйсэн явдлын талаар доор дэлгэрүүлэн үзье. Эрсдэлийн олон шинж нь тус сэдвийг олон талаас судлах боломж олгодог. Ялангуяа хувь хүн өөрөө аюулыг хайж байгаа процессыг олон эрдэмтэд судалсан байдаг. Тэдний заримаас дурдвал францын эрдэмтэн Д. Бретон, Естерл-Едибел... гэх мэт байна. Бид тэдний дэвшүүлсэн санаануудын талаар доор ярилцах болно.

Нийгэм болон аюул

Аз сорьсон үйлдэл нь нийгмийн шинж чанартай байдаг. Аз сорьсон үйлдлийг бид аюул гэдэгтэй холбон дээр тайлбарласан. Аюулын тухай ойлголт нь орон зай болон цаг хугацааны явцад байнга өөрчлөгддөг. Тэрчлэн аз сорьсон үйлдлийг үйлдэх, түүнээс татгалзах мөн тэр үйлдлийнхээ аюултай гэдгийг огт мэдэхгүй байх зэрэг нь нийгмийн нэг давхаргаас нөгөө давхаргад, нэг соёлоос нөгөө соёлд шилжихэд харилцан адилгүй. Аз сорьсон үйлдлийг үйлдэх нь хүмүүсийн хүмүүжил, боловсрол, нийгэмд эзэлж буй байр суурь зэргээс шалтгаалж өөр өөр байна. Ямар нэгэн аз сорьсон үйлдэл нэг соёлд аюул гэж ойлгогддог байхад нөгөөд жирийн

үйлдэл мэт санагддаг. Жишээлбэл, Монголд хурдан морины уралдаанд хүүхдүүд морь унадаг. Оролцож байгаа хүүхдүүд учирч болох ослоос урьдчилан сэргийлэх дорвитой хамгаалалтууд хэрэглэдэггүй. Уралдааны үеэр хүүхдүүд мориноос унаж болзошгүй гэсэн үүднээс түргэний машин дагаж явдаг. Хэдийгээр хүүхэд мориноос унаж болзошгүй гэж мэдэж байгаа боловч бид энэ үйлдлийг аюултай үйлдэлд тооцдоггүй мэт. Харин энэ нь аль ч гадны орныхны хувьд аюултай үйлдлийн тоонд багтдаг. Энэхүү үйлдлийг аюултай, эрсдэл дагуулсан үйлдэл гэдэгт тооцуулахаар саяхнаас нийгэмлэгүүд ажиллаж эхлээд байгаа.

Аюул гэдэг ойлголтыг нийгмээрээ бий болгодог. Аль ч цаг үед нийгэм аюул гэсэн ойлголтыг олон нийтэд хэвшүүлдэг. Аюулгүй байдал гэдгийг төр, хууль, нийгэм, нийгэмлэгүүд, төрийн бус байгууллагууд хувь хүний үйл ажиллагаануудын дагуу тогтоож өгдөг байна. Эрсдэлээс болгоомжлож, сэргийлэх үйлдэл нь нийтээрээ хуваалцдаг санаа бодол юм. Тухайлбал, албан газруудын аюулгүй байдлын дүрэм. Нийгэм соёлын эрсдэлийн талаарх хэмжүүр нь хувь хүн болон хүн амыг бүхэлд нь эрсдэлтэй харилцах харилцааг тогтоож өгдөг. Аль ч нийгэм нийтээрээ хүлээн зөвшөөрсөн эрсдэлтэй үйлдлийн хязгаарыг тогтоож өгдөг. Энэ нэгдсэн зарчим нь тодорхой цаг хугацаанд нийтээрээ хүлээн зөвшөөрсөн аюулын тухай ухагдахууныг гаргаж өгдөг. Жишээлбэл, Европт XIX-р зууны үед хүүхдийн нас баралт, эндэгдэлийг аюул гэдэг категорт хамруулдаггүй байсан болхоор үүний эсрэг ямар нэгэн урьдчилан сэргийлсэн эрүүл мэндийн арга хэмжээ авдаггүй байжээ. Харин XX-р зуунд энэ нь аюул гэдэг багцад багтсанаар хүүхдийн нас баралттай холбоотой асуудлуудыг бага багаар нухацтай авч үзэн үүний эсрэг

урьдчилан сэргийлэх шинж чанартай (вакцинжуулалт, нярай хүүхдийг эмчийн үзлэг хяналтанд оруулах) арга хэмжээнүүдийг авах болсон. Үүнээс үзэхэд аюул гэдэг нь байгууллагуудаас бий болгосон олон нийтээр хүлээн зөвшөөрүүлсэн ойлголт байна.

Хувь хүний эрсдлийг мэдрэх чадвар

Хүний насны байдлаас шалтгаалж эрсдлийг мэдрэх чадвар олон янз байдаг байна. Энэ талаар судлаач Бретон (Breton) сонирхолтой судалгаа хийсэн байдаг. Түүний судалснаар хүүхдийн том хүнтэй адил орчин тойрныгоо харах чадвар хөгжөөгүй байна. 10 буюу 12 наснаас өмнөх насны хүүхдүүдийн эргэн тойрноо харах чадвар нь 70° градуст багтдаг байхад том хүний эргэн тойрноо харах чадвар дунджаар 180° байдаг байна гэж судалгаагаар харуулжээ. Хүүхдэд зөвхөн эгц урагшаа харах чадвар суусан байдаг бөгөөд түүний хажуу талуудаа харах чадвар том хүнийхээс эрс муу байна. Мөн хүүхэд хийж буй үйлдэлдээ хамаг анхаарлаа төвлөрүүлдэггүй учраас учирч болох аюулаас урьдчилан сэргийлэх явдал бараг ажиглагддаггүй байдаг. Тэрээр холын зай болон ирж байгаа машин, мотоциклын хурдыг тооцоолж чаддаггүй байна. Мөн хүүхэд хэд хэдэн үйлдлүүдийг нэгэн зэрэг хийх чадвар муутай байдаг. Тиймээс 10-12 наснаас бага насны хүүхдүүд бие хүн болж төлөвших, аюулаас хамгаалахад сурч боловсрохоосоо урьтаад харах чадвараасаа шалтгаалж аюул осолд өртөж болох хандлага илүүтэй байна. Хүүхэд орчин тойрондоо байгаа аюул ослыг мэддэггүй учраас түүнд өөрсдөө өртөж, бэртэж, өвдөж байж бага багаар тэдгээр аюулуудыг таньж авдаг байна. Өөрөөр хэлбэл хүүхэд аюулыг мэдрэх болон түүнээс болгоомжлох гэсэн хоёр ухагдахууныг өөрсдийн биеэрээ туулсаны үр дүнд мэдэж авдаг байна. Тиймээс аюулын эсрэг биеэ хамгаалах

чадварт суралцсан, ахмад хүмүүсийн зөвлөгөө болон орчноосоо олж авсан туршлага зэрэг нь хүүхдэд аль болох аюулаас биеэ хамгаалах, түүнээс зайлсхийх чадварыг эзэмшүүлдэг байна. Мөн тэд хийж байгаа үйлдэлдээ илүү анхааралтай хандаж сурдаг байна. Хүүхэд эргэн тойрныхоо хүмүүсийн хэрхэн үйлдэх, биеэ авч явахыг ажиглан харж, хуримтлуулсан туршлагатайгаа хослуулж амьдралдаа хэрэгжүүлэх ба биеэ хэрхэн хамгаалах загварыг боловсруулахад сурдаг. Аюулыг мэдрэх, биеэ хамгаалах явдал нь төрөлхийн чадвар биш, хүмүүжил туршлагаас олж авсан чадвар юм. Хэдийгээр аюул хүний амьдралд оршин байдаг боловч хүн хамгийн энгийн, өдөр тутмын аюул ослоос өөрийгөө хамгаалахад суралцсан байдаг. Нас ахих тутам бид учирч болзошгүй аюулыг илүү тооцоолж сурдаг.

Аз сорьсон үйлдэл хөгжлийн хүч байж болох уу?

Аз сорих үйлдэл эерэг ба сөрөг утгатай гэж бид дээр дурьдсан. Эерэг утга нь амьдрал болон хөгжлийн түлхэх хүч гэдэгтэй утга дүйцнэ. Үүнийг франц хэлний зарим зүйр үгүүд тод томруунаар илэрхийлсэн байдаг: “*la chance sourit aux audacieux*” (эрсдэлтэй үйлдэл аз авчирна) “*qui ne risque rien, n’a rien*”, (азаа сориогүй нь хоосон хоцорно) гэх мэт. Нэг үгээр азаа үзэх нь аз дагуулж болзошгүй гэсэн утга агуулгыг илэрхийлж байна. Эн тэргүүнд аюулгүй байдлыг давууд авч үзвэл магадгүй бид зогсонги байдалд орж болзошгүй юм. Зогсонги байдал нь хувь хүн амьдрах хугацаандаа нээж болох бүхий л боломжуудыг алдах сөрөг талтай юм. Мөн аюулгүй байдлыг тогтмол хангах нь хүний аюулаас болгоомжлох анхаарлыг саринуулж, учрах аюулыг урьдчилж тооцох чадварыг сааруулах муу талтай байдаг. Харин азаа турших үйлдлийг хөгжлийн түлхэх хүч болж чадна гэж хэлж болно.

Хүн төрөлхтний хөгжил азаа сорих үйлдэлтэй нягт холбоотой байдаг. Жишээлбэл, аливаа судлаач туршилт хийхдээ урьдчилж ямар үр дүн гарахыг хэлж мэддэггүй. Дөнгөж хөлд орж байгаа хүүхдээс авахуулаад шинжлэх ухааны шинэ нээлт ололтууд хүртэл аз сорьсон явдлуудаас олонтой бий болдог. Тэгэхээр хүн болгон азаа үзэхээс татгалздаг байсан бол урагшилж дэвших байдал нилээд саарах магадлалтай. Үүнээс дүгнэхэд аз сорьсон үйлдэл нь хүнд хөгжих бололцоо олгодог эерэг утгатай холбогдож байгааг бид харлаа.

Аз сорьсон үйлдэл болон залуучууд

Хүний амь нас нэг талаас эрсдэлд өртөх, нөгөө талаас эрсдэлээс биеэ хамгаалах хоёрын дунд оршино. Гэтэл маш олон оронд хүмүүс өөрсдөө эрсдэлтэй учрахыг илүүд үздэг. Ялангуяа европт өсвөр насныхны дунд спортын болон биемахбодын хэт эрсдэлтэй шалгуурууд болох үйлдлүүд ихээхэн тохиолддог. Францад 40-өөд жилийн өмнөөс азаа сорьж хурд хэтрүүлэх, улаан гэрлээр гарах, архи дан согтуурах, мансууруулах бодис хэрэглэх зэрэг амь дүйсэн үзэгдлүүд олны дунд газар авсаныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сүүлийн үед нилээдгүй бичих болжээ. Le figaro сонинд “Залуучуудын биеэ авч явах байдал нь тэднийг амь насаараа тоглож байна гэж хэлмээр санагддаг. Тэдний энэ байдал зөвхөн өөрсдийнхөө амь насаар тоглоод зогсохгүй бас бусад хүмүүс түүнд өртөх аюултай” гэсэн нийтлэлүүд ихэд хэвлэгдэх болсон. Сонирхолтой нь олон нийтийн санаа зовж байгаа байдал ба азаа туршиж байгаа хүн өөрийнхөө үйлдэлд өгч байгаа утга хоёрын хооронд маш их зөрөө байна. Аюул осолтой азаа сорьж байгаа хүний хувьд ухамсартай үйлдэл гэхээсээ илүү төсөөллөөр өөрийгөө зориглодог нь харагддаг.

Эрдэмтэн Бретон хувь хүн өөрийнхөө амьдралд, мэргэжлийн ажилд

мөн чөлөөт цагтаа азаа турших явдлууддаа үйлдэгч этгээд ямар утга агуулга өгч байгааг судалсан байна. Азаа турших явдалд нэг талаас аюулгүй байдлаа хангах үүднээс аюулгүй байх “шаардлага”, нөгөө талаас болгоомжлолыг даван гарах “хүсэл” хоёр зэрэгцэн оршдог хэмээжээ. Азаа турших явдал нь ихэвчлэн таашаалал, бусад хүмүүсийн олж үзээгүй мэдрэмжийг мэдрэх хүсэл хоёртой холбоотой байна. Тиймээс энэ явдал нь өвдөх шаналах зовлонгоос илүүтэй бусдаас давуу байх гэсэн ойлголттой холбогддог. Энэ нь ялангуяа өсвөр насны залуучуудын дунд нийгэмд өөрсдийнхөө байр суурийг баталж өгөхийн тулд хийж байгаа шалгуур болдог.

Аюулыг ухамсарлах байдал сэтгэл хөдлөлийг давахад хангалттай бус байна. Залуучууд аюулыг ухамсарладаг ч өөрсдийнхөө хийж буй үйлдэлдээ хандуулж байгаа сэтгэлийн хөдөлгөөн нь аюулаас илүү хувьтай байна. Тиймээс амь насаараа дэнчин тавьсан үйлдлүүд болох машинтай уралдаж ролкоор гулгах, машин тэрэг барихдаа дүрэм зөрчих зэрэг үйлдлүүдийг тоочиход илүүдэхгүй. Энэ нь тэдний нийгэмтэй харьцаж байгаа нэгэн төрлийн харьцаа болохыг тэмдэглэх хэрэгтэй. Зарим үед аюулыг ухамсарлаж байгаа ухамсар нь азаа турших явдал эсвэл өөрсдийнхөө чадварын хязгаарыг мэдэх явдал руу тэднийг өдөөн хатгадаг эсрэг нөлөөтэй байна.

Амь дүйсэн үйлдэл нь мөн үүнийг аюултай гэж ойшоож үзээгүйгээс бас шалтгаална. Естерл-Едибел (Esterle-Hedibel) судалгааныхаа үр дүнд залуучуудын аюулыг мэдрэх мэдрэмж бусдаас илүү эсвэл тэд хэтэрхий залуу учраас үхэлтэй учрахгүй гэж боддог гэдгийг тодруулжээ. Тэд ярихдаа хэдийгээр бид аюул тохиох олон үйлдэл давтан хийдэг боловч одоо болтол аваар осол эсвэл амь эрсдэх явдалтай

тохиолдоогүй гэжээ. Тэдний биеэ авч явах байдал эдгээр тайлбаруудтай холбоотой байж болох юм. Нөгөө талаас тэдний нийгэмд эзлэх байр суурь бага, тодорхой зорилгогүй, нийгмийн тогтсон хэв маягт баригдахыг хүсдэггүй. Мөн том хүмүүст итгэх хүсэлгүй эсвэл нийгмийн ажилтан, эмч нарын нэгэн хэвийн яриаг сонирхохоо больсон зэрэг байдлууд тэднийг азаа турших үйлдэлд улам тэмүүлэх хүслийг лавшруулж өгдөг байна.

Хинтермеиер (Hintermeyer, 2002) судлаачийн үзсэнээр өсвөр насныхан эрсдэлтэй тоглож байх явцдаа өөрсдийнхөө биемахбодод хэр зэрэг эзэн болж чадаж байгаагаа туршиж үздэг гэж бичжээ. Мөн тэд өөрсдийнхөө чадварийг давхар соридог байна. Өсвөр насныхан өдөр тутмын амьдралд давтагддаг энгийн үйл явдлуудыг эвдэж адал явдал руу тэмүүлэх нь олонтой. Нэгэн хэвийн амьдралын хэмнэлийн хязгаарыг давна гэдэг нь адал явдалтай учирна гэсэн үг. Аюул сөрж азаа турших үед хүн бүх хүч тэнхээгээ дайчилдаг учраас биеийн бүхий л эд эрхтэнүүдийг идэвхтэй ажиллагаанд оруулж байгаа мэт санагддаг байна. Тиймээс тэдэнд хамаг бие сэтгэлээрээ амьдарч байгаа мэт сэтгэгдэл төрдөг. Судлаач Волтански (Boltanski) аюулаас айх хязгаараас хальж эрсдэл рүү өөрсдөө тэмүүлдэг байдлыг энэ маягаар тайлбарласан байна.

Харин хүүхэд өсвөр насанд шилжих үед азаа сорих явдал бусдын өмнө гавъяа мэт харагддаг гэж тэдэнд санагддаг байна. Мөн энэ насанд азаа сорих явдал нь хүрээлэн байгаа нийгэмдээ өөрсдийнхөө төрхийг батлан харуулах гэсэн залуучуудын хүсэл болно. Орчин үеийн хүн буюу залуу хүн ийм байх ёстой гэсэн ойлголтын улмаас азаа турших явдал их байдаг. Өсвөр насныхны хувьд үхлийн талаарх ойлголт арай л бодит бус байдаг. Тиймээс аз туршсан үйлдэл хийснээс болж

биемахбодоороо амсаж болох аюулыг тэр болгон хангалттай тооцоолдоггүй байна. Харин ч тэд үхлийг сорьж, түүнтэй тоглодог явдал давуу ажиглагдана. Тэд үүнийгээ тайлбарлахдаа ихэвчлэн тэдний аюулыг мэдрэх мэдрэмж бусдаас илүү эсвэл хэтэрхий залуу учраас тэд үхэлтэй учрахгүй гэж ойлгодогтой холбоотой байна. Үүнээс харахад үйлдэгч, аюул хоёр нь тус тусдаа биеэ даасан хэсгүүд бөгөөд хоорондоо ямарч холбоогүй мэт.

Гэхдээ азаа турших явдал нь бас хүйсээс шалтгаалж өөр өөр ажиглагдана. Эмэгтэй, эрэгтэй хүүхэд хоёрын аз сорих үйлдэл хоорондоо ялгаатай. Эрэгтэй хүүхдүүдийн азаа сорьж буй үйлдлүүдийг харахад гадагшаа чиглэсэн шинжтэй байна. Тэд азаа сорих үйлдэлд биемахбодоороо түлхүү оролцдог. Мөн хууль дүрэм зөрчдөг үйлдлүүд ихээр ажиглагддаг. Жишээлбэл, зодоон цохион хийх, согтууруулах ундаа болон мансууруулах бодис хэрэглэх, гэмт хэрэг зөрчилд өртөх, машин болон мотоциклын аваар осолд орох гэх мэтийг дурдаж болно. Харин охидууд сэтгэл зүйтэй холбоотой үйлдлүүд түлхүү хийдэг байна. Тэдний азаа сорих үйлдлүүдийг харахад дотогшоо чиглэсэн шинжтэй. Жишээлбэл, хоолноос гарах эсвэл хоолонд хэт орох, мөн сэтгэл санааны гутралд илүү орж тэрчлэн амиа хорлох явдал ч гарах үеүд олонтой тохиолдоно. Өөрөөр хэлбэл, тэдний азаа туршдаг үйлдлүүд хүний нүдэнд ил тусдаггүй, ихэвчлэн өөрлүүгээ чиглэсэн шинжтэйг ажиглаж болно. Харамсалтай нь нийгмийн шинжлэх ухаанд охидын үйлдэж буй эрсдлийг тэр болгон судалдаггүй, харин хөвгүүдийн үйлддэг аз сорьсон явдуудыг олонтоо судалдаг нь харагдлаа. Тэгэхээр эрсдэлийг санаатайгаар өдөөх явдал хүний нас болоод хүйснээс хамаардаг болох нээ.

Бусдын нөлөөн дор азаа сорих

Хэдийгээр бид азаа турших үйлдлийн эцсийн шийдвэрийг зөвхөн хувь хүний хүсэлтэй холбож үздэг бол найз нөхдийн нөлөө мөн энэхүү үйлдлийг гүйцэтгэхэд оролцдог гэдгийг үгүйсгэж болохгүй. Тиймээс тэдний нөлөө хэрхэн тусдаг талаар авч үзье. Бусдын нөлөөний талаар бид хоёр чиглэл барьж болно. Нэг талаас найз нөхөд тухайн хүний азаа сорих хүслийг дарж өгдөг гэж үздэг бол нөгөө талаас тэр хүслийг улам оргилуулдаг гэж үзэж болох байна. Ихэнх тохиолдолд хүмүүс ганцаараа байхдаа зориглож хийгээгүй зүйлээ бусадтай хамт байхдаа хийдэг. Энэ нь бусад хүмүүсийн нөлөө хувь хүний айдсыг ялахад нөлөөлдөг гэж хэлж болмоор санагдана. Зарим азаа сорих тохиолдол бүлэглэлийн дотоод шинж чанартай холбоотой байдаг. Жишээлбэл, судлаач Можегийн (Mauget) бичсэнээр зарим бүлгүүдийн гол бахархал нь аюул гэдэгтэй азаа турших явдал байдаг гэжээ. Тиймээс зарим бүлэг залуучууд амь дүйж эрсдэлтэй азаа туршихыг дэмжиж өгдөг учраас тэдний биеэ авч явах байдлын нэг хэсэг нь азаа сорих үйлдэл болж чадсан байдаг. Тэгэхээр аюултай гэдэг зүйлтэй азаа туршихыг эрэлхэг үйлс гэж үнэлж үздэг бүлэг залуучуудын хувьд найз нөхдийн нөлөө азаа сорих үйлдлийг улам дэвэргэж өгдөг. Тиймээс нэг нэгнийхээ нөлөөн дор үйлдсэн гэмт хэрэг, зөрчлүүд болон аваар осол олонтой тохиолддог жишээнүүдийг тоочиж барашгүй. Тэр дундаа сургуулийн дотоод дүрэм журмыг санаатайгаар зөрчих, хоорондоо хүчээ үзэх, хурд хэтрүүлэх зэрэг явдлууд бидэнд дасал болжээ. Аюулыг сөрж азаа үзнэ гэдэг нь заавал ямар нэгэн юмны шалгуур болдог байна гэж Бретон бичсэн байдаг. Бусдын нүдэнд өөрийнхөө байр суурь, хүч зоригийг гэрчлэх зорилгоор аюул гэдэг зүйлтэй азаа турших явдал бас байна. Хэдийгээр энэ тохиолдолд найз нөхөд азаа сорих

явдлыг шаарддаггүй ч зөвхөн тухайн хүнийг тойроод байж байгаа нь азаа сорих үйлдлийг хийхэд хангалттай байна.

Судлаач Esterle-Hedibel (Естерл-Едибел) бүлэглэлийн нөлөөг өөр маягаар тайлбарласан байдаг. Түүний үзэж байгаагаар хэрвээ бусад хүмүүс тухайн хүнд аз сорьсон үйлдлийг хийхэд нөлөөлдөг гэж үзвэл юуны өмнө тухайн хүний бүлэг дэх оролцоог тогтоох хэрэгтэй. Энэ нь тухайн хүний бүлгийнхээ үндсэн чанарыг хэр зэрэг хүлээн авахыг харуулж чадна. Хэн нэгэн тухайн бүлэгтээ дагалдагчийн үүрэг гүйцэтгэдэг бол тэр хүний хувьд аюул сөрж азаа турших нь тийм чухал зүйл болж чадахгүй. Нөгөөтэйгүүр өөрөө сонгож азаа турших эсвэл бусдын нөлөөнөөс болж азаа турших хоёр хоорондоо ялгаатай. Бретоны хэлснээр зөвхөн өөрөө чөлөөтэйгээр сонголт хийж азаа турших нь бусдын бахдал болж чадна гэж бичсэн байдаг. Тэгэхээр өөрөө чөлөөтэйгээр сонголт хийж аюул сөрж азаа үзэх нь хүч чадлаа сорьсон сорилт болж чадах юм.

Сургууль завсардсан хүүхдүүдийн азаа турших явдлууд

Бид өмнөх хэсгүүдэд эрсдэлийг судлаачид хэрхэн авч үздэг болон үүнтэй холбоотой онолуудын талаар ярилцсан. Аюул сөрж тоглох үзэгдэл залуучуудын дунд ихээхэн харагддаг учраас бид монгол дахь сургууль завсардсан хүүхдүүдийн азаа үздэг байдлыг сонирхоё. Дээр дурдсан эрсдэлтэй холбоотой онолуудыг барууны судлаачид томъёолсон учраас эдгээр концептууд монголын нөхцөлд нийслэл хотын хөгжлийн явцтай хэр зэрэг нийцэж байгааг авч үзье.

Эхлээд хүүхдүүдийн харах чадвартай холбоотой судалгааг авч үзэх нь зүйтэй байх. Дээр дурдсанаар харах чадвараасаа шалтгаалж хүүхдүүд эрсдэлтэй учрах нь олонтой тохиолддог

гэж бид тайлбарласан. Энэ нь хүүхдийн ослыг ойлгоход тус нэмэр болно. Ялангуяа сургуулийн насны хүүхдүүд машины аваар осолд олонтой өртдөг. Хүүхдүүд машины хурдыг тэр болгон мэдэрдэггүй. Машин их хурдтай ирж байхад өмнүүр нь гарах явдал олонтой үзэгддэг. Энэхүү осолд сургууль завсардсан хүүхдүүд түлхүү өртдөгийг бид халамжийн төвүүд эсвэл эмнэлэгийн тоо бүртгэлээс харж болно. Энэ нь тохиолдолын чанартай явдал биш байх гэж бодогдож байна. Тэдгээр хүүхдүүд замын дүрмийг мөрддөггүй нь дээрх осолд өртөх нэг шалтгаан болдог. Тэд явган хүний гарцаар гардаггүй мөн гэрлэн дохиог анзаарахгүй зам хөндлөн гардаг, хурдтай ирж яваа машины өмнүүр гүйдэг зэрэг жишээнүүдийг дурдаж болно. Харин сургуульд сурдаг хүүхдүүд замын хөдөлгөөний дүрэм журмыг илүү мөрддөг. Эдгээр хүүхдүүдийн биеэ авч явах чадвар хотын хөдөлгөөнд илүү дасан зохицсон гэж хэлж болно. Энэ нь бага ангийн багш нар тэдэнд замын хөдөлгөөний дүрэм заах, сургуулиуд замын хөдөлгөөнтэй холбоотой сэдвээр үзүүлэн тоглолтууд хийх, зурагт хуудас үзүүлэн самбарууд гаргах, мөн тухайн сэдвээр дуу заах зэрэг нь тэдэнд аюул ослыг ойлгох түүнээс сэрэмжлэх боловсрол олгодог. Тэрчлэн эцэг эхийн оролцоо аваар ослоос сэргийлэх бас нэгэн сургууль болж өгдөг. Эцэг эх, багш сурган хүмүүжүүлэгчдийн байнга давтан хэлдэг сэрэмжлүүлгийн үр дүнд тэдгээр хүүхдүүд учирч болох аваар ослыг урьдчилан мэдрэх, ямар нэгэн аюулаас өөрсдийгөө хамгаалахад суралцдаг. Хэдийгээр ийм зөвлөгөө, санамж, сургалт байлаа ч тэд мөн л замын осолд өртдөг.

Сургууль завсардсан хүүхдүүд эдгээр зөвлөгөө, санамжаас хол байдаг учраас тэд замын осолд нилээд өртдөг. Тухайлбал, тэдгээр хүүхдүүд хөдлөж

буй автобусруу үсэрч орох явдал их ажиглагддаг. Ингэхдээ тэд өөрсдийнхөө чадварын хязгаарыг мэддэггүй, энэхүү үйлдэл нь тэдэнд тоглоом наадмын нэг хэлбэр мэт санагддаг (Амарсанаа, 2004). Тиймээс энэхүү үйлдэл нь тэдэнд аюул эрсдэл дагуулна гэсэн бодол огт төрүүлдэггүй. Дээр нь тэднийг хүрээлэн байгаа хүмүүс мөн л замын хөдөлгөөний дүрэм журмыг мөрддөггүй. Тиймээс тэдгээр хүүхдүүдэд замын аваар осолд өртөх ойлголт тэр болгон төрдөггүй байна.

Дээр нь жолоочдын анхаарал болгоомжгүй байдал, дүрэм зөрчих зэрэг хариуцлагагүй үйлдлээс болж осол аваар олонтоо гардаг. Сүүлийн жилүүдэд машины тоо эрс нэмэгдсэн ч үүнийг даган жолооч нарт бусдыг хүндлэх, явган хүнд анхаарал тавих зэрэг орчинтойгоо зохицох төлөвшил, соёлыг хурдтай эзэмшээгүй нь харамсалтай байна. Мөн туршлага багатай шинэ жолооч, согтууруулах ундаа хэрэглэн жолоо барих, хурд хэтрүүлэх зэрэг хүчин зүйлээс шалтгаалж хүүхэд тэрчлэн том хүний амь насыг хохироосоор байна. Эдгээр баримтууд нь хүүхдүүдэд тохиолддог ослыг нэмэгдүүлэх бас нэгэн хүчин зүйл болдог.

Бретон, Естерле-Едибел нарын дэвшүүлсэн санаанууд болох эрсдэлийг урьдчилж тооцоолох гэдэг нь хүнд төрхөөс заяасан чадвар биш харин түүнийг хүн сурч эзэмшдэг гэдгийг дээрх жишээнүүд нотлогдож байна. Харин нэмж хэлэхэд энэхүү чадварыг эзэмших явц харилцан адилгүй байгааг бид сургуульд сурч байгаа болон сургуулиас завсардсан нэг үе тэнгийн хүүхдээс харах боломжтой байна.

Амь сорьсон явдлуудыг үйлдэгч ухамсартайгаар буюу санаатайгаар үйлддэгийг судлаачид харуулсан. Ихэнх судлаачид спортын амь дүйсэн үйлдлүүдийг жишээ болгон татдаг. Тухайлбал цанаар 200 км/цагийн

хурдтай гулгах нь осолд өртөх шалтгаан болж өгдөг гэх мэт. Мөн “аюултай тоглох” гэсэн сэдвээр хийгдсэн олон судалгаа нэг гол асуудал болох мансууруулах бодис нь судлаачдын сонирхлыг маш ихээр татсаар ирсэн. “Гудамжны” гэгдэх хүүхдүүд, сургуулиас завсардсан хүүхдүүд мансууруулах төрлийн бодис ямар нэг хэмжээгээр хэрэглэдэгийг бид мэднэ (Амарсанаа, 2002). Харин энэхүү үйлдэл нь тэдний эрүүл мэндэд муугаар нөлөөлдөг гэдгийг тэд ухамсарлан ойлгож байгаа болов уу? Ихэвчлэн тэдний энэ үйлдэл нь агшин зуур тааламжтай мэдрэмж олж авахтай холбоотой. Тэгвэл дээрхи судлаачдын үзсэнээр эрсдэлтэй тоглохыг ухамсарт үйлдэл гэж тайлбарласан нь энэхүү жишээн дээр нийцэхгүй байгааг бид харж байна. Магадгүй эдгээр концепцууд тэдний соёлын хэв шинжид илүү тохирсон байх магадлалтай юм.

Эцэст нь дүгнэхэд, бид эрсдэл гэдэг утгын талаар хэд хэдэн судлаачдын

судалгаануудтай танилцаж, тэдний тайлбар утгуудыг сонирхсон.

Эрсдэлтэй үйлдлүүд нь хүний нас болон хүйсээс шалтгаалан хоорондоо ялгаатай байсан. Хүрээлэн буй орчин эрсдэлтэй үйлдлийн нэгэн шалтгаан хэмээн бид нэмж оруулсан. Учир нь үе тэнгийн хүүхдүүд өөрсдийн хүрээлэн буй орчноос шалтгаан аюул ослыг ухамсарлах нь өөр өөр байсан.

Аз сорьсон үйлдлийг ухамсаргүйгээр болон ухамсартайгаар үйлддэг. Эрсдэл болон хөгжил хоёрын зааг нь өөрөө тодорхой бус байдагт гол зангилаа оршиж байна.

Хүний айдас нь байгалиас заяасан шинжтэй бол аюул осолтой азаа турших нь нэг ёсондоо байгалийн хуулийг зөрчиж байгаа мэт санагдана. Аюул осол сөрж азаа турших нь хүн төрөлхтөнд бий болсон шинэ маягийн биеэ авч явах байдал юм болов уу. Хэрэв тийм бол байгаль, соёл хоёрын зөрчилдөөн гэж дүгнэж болох байна.

НОМ ЗҮЙ

- Амарсанаа А., 2002. Монгол дахь гудамжны гэгдэх хүүхдүүдийн талаарх судалгаа. Магистрын ажил, Франц, Лилл хотын 3-р их сургууль.
- Амарсанаа А., 2005. “Гудамжны хандлагатай хүүхдүүд” судалгааны оршил эрэгцүүлэл. *Mongolian Journal of Anthropology, Archaeology and Ethnology*. Vol.1, № 1 (242) May. х.101-111.
- Дорждэрэм Л., 2011. Франц-Монгол толь.
- Assailly, J.P., 1992. *Les jeunes et le risque*, Paris, Vigot.
- Augé M., & Herzlich C., 1984. *Le sens du mal. Anthropologie, histoire, sociologie de la maladie*. Paris, Archives contemporaines.
- Boltanski L., 1971. *Les usages sociaux du corps*. Annales Economie, Société et Civilisation, Vol. 1, p. 206-233.
- Psychologie du risque*. 1994. Homo XXXIII.
- Esterle-Hedibel M., 1997. *La bande, le risque et l'accident*. Paris, Editions L'Harmattan, 1997.
- Hintermeyer P., 2002. Les mots et les coups. In *L'adolescence à risque*, dirigé par Le Breton, D., Paris, p. 48-64.
- Lascoumes P., 1993. Construction sociale des risques et contrôle du vivant. *Prévenir*, Vol. 24, p. 23-37.
- Le Breton, D., 1991. *Passions du risque*, Paris, Editions Métailié.
- Le Breton D., 1995. *La sociologie du risque*, Paris, PUF.
- Le Breton D., 2002. La vie en jeu, pour exister. In *L'adolescence à risque*, dirigé par Le Breton, Paris, p. 14-36.
- Loret A., 2002. Le sport extrême. In : *L'adolescence à risque*, dirigé par Le Breton D., Paris, p. 37-45.

- Mauget G.*, 1993. Les usages politiques du monde des bandes. In : *L'engagement politique : déclin ou mutation*, Paris, CEVIPOF, FNSP.
- Paillard B.*, 1993. Appréhender les peurs. In : *Communications*, dirigé par Paillard B., Seuil, p. 7-15.
- Robert P.*, 1995. *Le petit Robert : dictionnaire de la langue française*.

SUMMARY

TAKING THE RISK: DANGER OR DEVELOPEMENT ?

A.AMARSANAA

The risk is divided into two contrast ideas according its result. One is positive and another is negative. Generally, the human being is afraid to take a risk because the man prefers protecting himself from the dangerous action. But nowadays some people are looking for running a risk to surpass themselves. Our article tries to analyze the behavior and the risk action among the young Mongolian people.

СУУГУУЛ НИЙГЭМ БОЛОН ЭХ НУТАГТАА БУЙ БУРИАДУУДЫН АВУНКУЛАР¹ НЭРШЛИЙН ЗҮЙРЛЭСЭН ХЭРЭГЛЭЭ

САЯАНА НАМСАРАЕВА

Кэмбрижийн Их Сургуулийн Монгол, Дотоод Ази Судлалын Төв,
и-мэйл: sn444@hermes.cam.ac.uk

ТҮЛХҮҮР ҮГС: буриад диаспора, буриад нагац талын харилцааны ураг төрлийн нэршил, гэрлэлтийн холбооны харилцаа, хамаатан садны тухай хэлц, оросын колониализм, эх нутаг болон суугуул нийгэм

ТОВЧ АГУУЛГА. Нагац хоорондын ураг төрлийн харилцаа (*avunculate*) нь нийгмийн хүн судлалын түүхэнд хамгийн их судлагдсан сэдвийн нэг билээ. Шнайдерээс өмнөх үеийн хоёр онол болох удмын болон холбооны онолууд нагац талын харилцааг; хэн нэгэн хүн, нагацыгаа өөрөөсөө дээгүүр байр суурьтай гэж хүлээн зөвшөөрөх ч заримдаа түүнтэйгээ зөрчилдөж байдаг гэж үздэг. Энэ өгүүлэл дээрх сонгодог антроплогийн үзэл болон өнөө үеийн буриадын улс төр, нийгмийн бодит байдал хоёрын хооронд холбоо хамаарал байгаа эсэхийг тогтоох юм. Ялангуяа диаспора буриадуудын эх нутаг болон суугуул нийгэмтэйгээ харилцах харилцааны шинэ агуулга болсон нагац талын ураг төрлийн харилцааны нэршлийн зүйрлэсэн хэрэглээний тухай хөндөхийг хичээсэн юм. Сүүлийн үеийн хандлагаар ураг төрлийн нэршил нь олон төрлийн агуулгатай, уян хатан төдийгүй удмын холбоо хамаарал гэхээсээ илүү нийгмийн харилцаа гэж ойлгох ёстой эд ажээ. Би өгүүлэлдээ Монгол Улс, Өвөр монгол дахь буриад диаспора нарын жишээгээр хэрхэн тэд нагац талын харилцааны тухай ойлголтыг ашиглан Орос дахь эх нутгийг нь колоничлогчид болон нийгмийн тэгш бус байдал ихтэй суугуул нийгэм хоёрын хоорондох харилцааны зөрчил, ойлголтыг тодорхойлж буйг харуулах юм. Энэхүү ураг төрлийн нэршил нь нийгмийн өргөн ач холбогдолтой төдийгүй орон нутгийн түвшинд улс төрийн өөрчлөлтийн нөлөө, хүчний тэгш бус байдлын илэрхийлэл болох боломжтой гэж үзлээ.

УДИРТГАЛ

Би энэхүү өгүүллээ 2007-2009 онд Монгол Улсын зүүн хойд хэсэг (Дорнод, Хэнтий аймаг), Хятад (Өвөр монголын Хөлөн буйр) дахь (Зураг 1) буриад¹ болон тэдний эх нутаг болох ОХУ-ын Зүүн Сибирийн Буриад, Забайкальский² нутгаар хийсэн хэд хэдэн угсаатны зүйн судалгааныхаа мэдээ баримтыг ашиглан бичлээ. Уг өгүүллээрээ буриадуудын дундаас хамгийн их нүүдэллэсэн Агын буриадын³ тухай болон буриад ураг төрлийн диаспор агуулга, нагац талын харилцааны ураг төрлийн нэршлийн зүйрлэсэн

хэрэглээний тухай хөндөх юм. Юун түрүүнд би буриадын ээжийнхээ ахтай (ЭА) болон эгч, эмэгтэй дүүгийнхээ хүүтэй (ЭД) харилцах харилцааг задлан шинжлэхийн хамт монголчуудын нагац талтайгаа харилцах харилцааны талаар товч дурдах болно. Мөн энэхүү нагац талын нэршлийг буриад шилжин суугсад нийгмийн ямар зорилгоор авч хэрэглэсэн болон одоо ямар нийгмийн агуулга байгааг судлах юм. Энд ярих буриадын хоёр жишээгээр тус шилжин суугсдын ЭА/ЭД харилцаанд байх нэгдүгээр биеийн (ego) хоёр өөр байр суурийг харуулна. Тэдгээр байр суурь нь: (1) ЭА-тай харилцах

¹ *Avuncular* гэдэг нь нагац талтайгаа онцгой харилцах харилцаа (Орчуулагч).